



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 4/91

Мандалговь

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймгийн ИТХ-ын 2021 оны 02 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 3.11 дэх хэсэгт тусгагдсан Төрийн үйлчилгээний байгууллагын засвар (Эрдэнэдалай сум) ажлын 10.000.000 (арван сая) төгрөгийн төсөвт, 4.7 дэх хэсэгт тусгагдсан “Эрдэнэдалай цогцолборын зураг, төсөв” боловсруулах 10.000.000 (арван сая) төгрөгийн ажлын нэр болон төсөвт өртөгт тус тус өөрчлөлт орсон тул эрхийг шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн ажлыг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжүүлэхийг Эрдэнэдалай сумын Засаг дарга (Б.Лхавгамандал), эрх шилжүүлсэн арга хэмжээний явцын мэдээллийг сар бүрийн 2-ны өдрийн дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тайлагнаж ажиллахыг дээрх сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210404